



БАТЛАВ.

РЕКТОР

Б.ОЧИРХУЯГ

ATA13089 9104399  
9024080427

## ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

### Түрээслэх эд хөрөнгийн танилцуулга:

Монгол Улсын Их сургуулийн Хичээлийн 8-р байрны талбайг цайны газрын зориулалтаар түрээслүүлнэ.

Эд хөрөнгө түрээслэх үнийн доод хэмжээ, талбайн м <sup>2</sup>	<p>— 1 давхарт байрлалтай, цайны газрын зориулалттайгаар 110.97м<sup>2</sup> талбай. Нэг м<sup>2</sup> талбайн түрээслүүлэх доод үнэ 15,000.00 (арван таван мянга) төгрөг (ашиглалтын зардал ороогүй дүнгээр). Уг талбай нь өмнө нь цайны газрын зориулалтаар ашиглаж байсан тавилга, тоног төхөөрөмжүүдтэй болно. Дэлгэрэнгүй зургийг МУИС-ийн цахим хуудсаас харна уу.</p> <p>/түрээслэх доод үнийг ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49, 51-р тогтоолыг үндэслэсэн/</p>
--	---

### Сонгон шалгаруулалтад бүрдүүлэх материал:

Түрээслэгч үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн мэдээлэл	Үндсэн үйл ажиллагааны чиглэл нь нийтийн хоол, зоогийн газрын үйлчилгээ эрхэлдэг байна. /нотариатаар баталгаажуулсан хуулбар/
Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл	<ul style="list-style-type: none"><li>Сонгон шалгаруулалтын материалыг тогтоосон хугацаанд битүүмжлэн эх болон хуулбар хувийг ирүүлнэ.</li><li>Бүрдүүлсэн материалын жагсаалтыг дугтуйны гадна талд бичсэн байна.</li><li>Эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байна.</li><li>Иргэн, хуулийн этгээд нь МУИС-ийн Хичээлийн 8-р байрны түрээсээр эзэмших ашигтай талбайд явуулах үйл ажиллагааны танилцуулга, Монгол Улсын стандарт MNS4946:2005-д /хэрэв өөрчлөгдсөн бол шинэчилсэнийг ирүүлэх/ зааснаар хоолны газрын ангилал, тусгай зөвшөөрөл, зэрэглэл, үндсэн шаардлагын хавсралт “B” /норматив/-ийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх, ажлын байрны зураг, техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлын үзүүлэлт ирүүлнэ.</li><li>Сонгон шалгаруулалтад оролцогч нь эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр үйлчлэх тухай БСМШУ, ЭМС-ын хамтарсан 2007 оны 336/247 тоот тушаалын 3 дугаар хавсралтыг /хэрэв өөрчлөгдсөн бол шинэчилснийг ирүүлэх/ дагаж мөрдөх, мөн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлүүдийг зөвшөөрч буй талаар мэдэгдэл, албан бичиг ирүүлнэ.</li></ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Оролцогч нь үйлчилгээ явуулах талбайтай танилцсан тухай албан бичиг ирүүлнэ.</li> <li>• Оролцогч нь сонгон шалгаруулалтыг нээхээс өмнө татгалзах саналаа ирүүлж болно.</li> </ul>
Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал	<p>Оролцогчид дараах материал бүрдүүлж ирүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Талбай болон үндсэн хөрөнгө түрээслэх үнийн санал албан бичгээр ирүүлэх;</li> <li>• Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ (иргэний хувьд цахим үнэмлэх), эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тус тус нотариатаар баталгаажуулсан хуулбар;</li> <li>• Үйл ажиллагааны танилцуулга;</li> <li>• Ажлын туршлагын талаарх мэдээлэл 2023, 2024 оноор (хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээний хуулбар);</li> <li>• Санхүүгийн чадварыг нотлох баримт 2023, 2024 оноор (иргэн бол харилцагч банкны тодорхойлолт, сүүлийн 1 жилийн дансны хуулга, хуулийн этгээд бол сүүлийн 2 жилийн аудитлагдсан тайлан, татвар, нийгмийн даатгалын тодорхойлолт);</li> <li>• Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд 1 сарын төлбөртэй тэнцэх хэмжээний барьцаа төлбөрийг МУИС-ийн дансанд байршуулах;</li> <li>• Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом, үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;</li> <li>• Татварын байгууллагын цахим тодорхойлолтыг бар кодын хамт ирүүлэх; /Тендер нээсэн өдрөөр өр төлбөргүй байх, өртэй бол татгалзах үндэслэл болно/;</li> <li>• Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын болон харьяа шүүхийн байгууллагаас зарга маргаанд холбогдолгүй талаарх албан бичиг ирүүлэх;</li> <li>• Худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны чиглэлийн технологийн баримт бичиг;</li> <li>• Багц хоолны нэр төрөл, цэс, үнийн саналыг жагсаасан жагсаалт ирүүлэх /технологийн картыг баталгаажуулж, өнгөтөөр зурагжсан байдлаар/;</li> <li>• Багш, оюутанд үйлчилгээ үзүүлэх хоолны нэр төрөл, цэс, борлуулах үнэ (багш, оюутанд үзүүлэх хөнгөлөлттэй бол үнэлгээнд харгалзан үзнэ)-ийн дэлгэрэнгүйг ирүүлэх;</li> <li>• Бэлтгэн нийлүүлэгчтэй хийсэн гэрээг ирүүлэх. Үүнд:</li> <li>• Махан, махан бүтээгдэхүүн,</li> <li>• Гурил гурилан бүтээгдэхүүн,</li> <li>• Төмс, хүнсний ногоо зэрэг гол өргөн хэрэглээний барааны бэлтгэн нийлүүлэгчтэй хийсэн гэрээг ирүүлэх;</li> <li>• Түрээсийн төлбөрөө 3 /гурав/ сараар урьдчилан төлөх санхүүгийн чадвартай, хөрөнгийн баталгаатай байх (холбогдох эрх бүхий байгууллагын баталгаа гаргуулах зэрэг);</li> <li>• Ажиллах хүчний тодорхойлолт, (ажилтнуудын эрүүл мэндийн шинжилгээний баримт бичиг нотариатаар баталгаажуулсан хуулбар),</li> <li>• Аливаа эрсдэл, даатгалыг оролцогч тал бүрэн хариуцах албан бичиг ирүүлэх;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>Оролцогч нь нэг жилийн хугацаанд тогтвортой ажиллахыг илэрхийлсэн албан бичиг ирүүлэх.</li> <li>Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх тоног төхөөрөмжүүдтэй байх ба жагсаалтыг зурагжуулан ирүүлэх.</li> </ul>
--	--

**Материал хүлээн авах хаяг , материал нээх хугацаа, байршил:**

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа	Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа <b>2025 оны 08-р сарын 29-ны өдрийн 10 цаг 00 минут.</b> /хугацаа хоцорсон материал хүлээн авахгүй/
Материал хүлээн авах хаяг	МУИС. Хичээлийн 1-р байр, 2 давхарт, 212 тоот, байгууллагын бичиг хэргийн ажилтанд. Утас: 75754400 (1601, 1602)
Материал нээх хугацаа, хаяг байршил	<p>Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо <b>МУИС-ийн Хичээлийн 1 дүгээр байрны 122 тоотод</b> сонгон шалгаруулалтын нээлт болно.</p> <p>Нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан материалыг <b>2025 оны 08-р сарын 29-ны өдрийн 10 цаг 30 минутанд</b> нээнэ.</p>

**Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах:**

Түрээслүүлэх байр, талбайг өмч зээмшигч Монгол Улсын Их сургуулийн тухайн барилга, давхар дээр дээр очиж үзэж болох бөгөөд сонгон шалгаруулалтын заавар, бүртгэх хугацаа зэрэг мэдээллийг 75754400 /1213, 1212/ утсаар авна уу.

**Хаяг:** СБД, 6-р хороо, Их сургуулийн гудамж 1, МУИС, Хичээлийн 1-р байр, 1 давхарт, 213, 122 тоот.

Хянасан: Хангамж үйлчилгээний газрын дарга З.Баярбаатар

Боловсруулсан: Хангамж үйлчилгээний газрын мэргэжилтэн О.Бэхтэр